

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН, ХУУЛЬ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

2026.09.11

Улаанбаатар хот

Нэг.Зорилго

1.1 Монголын Хуульчдын холбооны дүрмийн 8.8 дугаар зүйлд заасан Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Хоёр. Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны бүрэлдэхүүнд төлөөллөө оруулах эрх бүхий этгээд, төлөөлөгчдийн тоо

2.1 Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хороо нь хууль зүйн шинжлэх ухааны байгууллагын судлаач, эрдэмтэн, хууль зүйн сургуулийн багш хуульч профессоруудаас долоо, шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны тус бүр хоёр төлөөллөөс бүрдсэн арван гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Гурав. Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа

3.1 Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг 2026.09.11-ний өдрөөс 2026.09.16-ны өдрийн 17:30 цагийн хооронд явуулна.

3.2 Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны гишүүнд нэр дэвших сонирхолтой хуульч өөрөө нэрээ дэвшүүлнэ.

3.3 Монголын Хуульчдын холбооны зөвлөл нэр дэвшигчдээс энэ удирдамжийн 2.1-д заасан тооны хуульч профессоруыг Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролыг дэмжих асуудал эрхэлсэн хорооны гишүүнээр сонгоно.

Дөрөв. Нэр дэвшигчид тавигдах шаардлага

4.1. Нэр дэвшигч нь дор дурдсан шаардлагыг хангасан байна:

- 4.1.1 Тухайн нэр дэвшүүлж буй хорооны гишүүн байх; (хуульч профессорын төлөөлөлд энэ заалт хамаарахгүй)
- 4.1.2 Хууль зүйн чиглэлээр хийсэн судалгаа шинжилгээний ажил нь нийтийн хүртээл болсон байх.
- 4.1.3 Боловсролын зэрэг /Докторант эсхүл Доктор/
- 4.1.4 Сүүлийн гурван жилийн хугацаанд мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан үндэслэлээр хариуцлага хүлээгээгүй байх
- 4.1.5 Хуульчийн нийтлэг үүргийн зөрчилгүй байх

Тав. Бүрдүүлэх материал

5.1 Нэр дэвшигч нь дор дурдсан материалыг бүрдүүлж, Монголын Хуульчдын холбооны Тамгын газарт хүргүүлнэ:

- 5.1.1 Хавсралтаар оруулсан нэр дэвшигчийн товч анкет, 2 хувь цээж зураг (4х6 хэмжээтэй);
- 5.1.2 Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 5.1.3 Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар;
- 5.1.4 Хууль зүйн магистр ба түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- 5.1.5 Мэргэжлээрээ ажиллаж буй тодорхойлолт;
- 5.1.6 Бүтээлийн жагсаалт

Зургаа. Материал ирүүлэх хугацаа, хаяг

6.1 Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийн дэмжих асуудал эрхэлсэн хорооны гишүүнд нэр дэвшигчийн материалыг 2026 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 17:30 цаг хүртэл Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дор дурдсан хаягаар хүлээн авна.

Хаяг:УБ хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Хуульчдын ордон, 17 давхарт, 1702 тоот

Холбоо барих: Хороо хариуцсан мэргэжилтэн Т.Гүнбилэг утас-95800707

Цахим хаяг: Gunbileg.work@gmail.com

